БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ЧИНЗОРИГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь) | (Биелэлтийн хувь * 70 / 100%) |
| | | 94,2 | 66,0 |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Орон нутгийн болон бүсийн сургалтад оролцоно. | 100 | 15 |
| 2. | Хариуцсан салбарын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажлын байрандаа суралцана. | 100 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | *70 хүртэлх оноо*<br>*66,0* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>*15* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>*15* |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | ..... *оноо* |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 96,0 |

***Үнэлгээ өгсөн:***

***Төсвийн шууд захирагч***

АЗДТГ-ийн дарга .............................. /Ш. Эрдэнэбат/

2025.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

БОНХОБТХ-ийн дарга .............................. /Д.Чинзориг/

2025-12-09 (огноо)

**БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

2025.12.08 Есөнбулаг

| д/д | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний тоо |
|---|---|---|---|
| | Хяналтад авсан арга хэмжээний тоо | - | 85 |
| 1 | Бүрэн хангалттай<br>(арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) | 85-аас дээш хувьтай | 69 |
| 2 | Хангалттай<br>(шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах) | 70-85 хувь | 6 |
| 3 | Хангалтгүй<br>(удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон.). | 70 хүртэл хувь | 4 |
| 4 | Үнэлэх боломжгүй | - | 6 |
| | Хэрэгжилтийн дундаж хувь | | 94,2 |

__o0o__

**БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН**
**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025.12.08 Есөнбулаг

| д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ** | | | | | | | |
| | | | | | | | |
| 1 | 1.1 | Сангийн сайдын 2023 оны А/137 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал"-ын дагуу УТХО-аар 2026 онд хэрэгжүүлэх барилга, байгууламжийн урьдчилсан үнэлгээг хийж, заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид цахимаар илгээх. | Цахимаар илгээх саналын тоо | 1 | 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй нийт 32 төсөл, арга хэмжээний урьдчилсан үнэлгээг хууль, журамд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагч нарт Сангийн яамны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр илгээлээ. | 100 |
| 2 | 1.2 | Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулийн төсвийн төсөөлөлд тусгах УТХО-ын саналыг үнэлж, эрэмбэлэн 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Сангийн яамны цахим систем /https://publicinvestment.gov.mn/-ээр болон цаасаар Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх. | Хүргүүлэх саналын тоо | 1 | 1 | Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг хууль, журамд заасан хугацаанд буюу 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор үнэлж, эрэмбэлэн Сангийн яамны цахим систем /https://publicinvestment.gov.mn/-ээр Төсвийн ерөнхийлөн захирагч нарт илгээлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй саналын жагсаалтад 53 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр хүргүүлэн, 2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 202.7 тэрбум төгрөгийн 30 төсөл арга хэмжээг 52.9 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлагдлаа. | 100 |
| 3 | 1.3 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, үйл ажиллагааг Улсын төсвийн хөрөнгө | Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний тоо | 8 | 5 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлж буй орон нутагт эрх шилжиж ирсэн нийт 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэл болох нийт 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулалтын удирдлагын цахим систем /https://publicinvestment.gov.mn/-ээр хэрэгжүүлж, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлэх. | | | | хянан баталгаажуулж, Сангийн яамаар дамжуулан бүрэн олголоо. | |
| 4 | 1.4 | Орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хууль, журамд заасан хугацаанд санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулан, түүнд хяналт тавих | Хэрэгжилтийн хувь | 97 | 100 | Орон нутгийн төсвийн болон орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 11 төсөл, арга хэмжээний 0.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн цахим системээр болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу олголоо. | 100 |
| 5 | 1.5 | Аймгийн орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хууль, журамд заасан шалгууруудыг хангаи боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах. | Батлагдсан баримт бичгийн тоо | 1 | 1 | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 0.01 тэрбум төгрөгөөр 1 төсөл арга хэмжээг үргэлжлүүлэхээр, орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр 0.6 тэрбум төгрөгийн 5 төсөл арга хэмжээг үргэлжлүүлэхээр, 0.5 тэрбум төгрөгийн 4 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 9 дүгээр хуралдааны 64 дүгээр тогтоолоор тус тус батлууллаа. | 100 |
| 6 | 1.6 | ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем https://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д оруулах ажлыг зохион байгуулж, тус сангийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх. | Хэрэгжилтийн хувь | 96 | 100 | Орон нутгийн хөгжлийн сангийн УМС-д /https://tusuv-oronnutag.mof.gov.mn/ сайтад 2024 онд хэрэгжүүлсэн 93 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн оруулсан бөгөөд 2025 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг тухай бүр оруулан ажилаж байна. | 90 |
| 7 | 1.7 | https://shilendans.gov.mn/ сайтад Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүрийн 08-ны өдрийн дотор оруулах | тоо хэмжээ | 0 | 12 | Улс, орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүрийн 8-нд шилэн дансны системд бүртгэдэг бөгөөд жилийн эцсийн байдлаар УТХО-аас 4, ОНТХО-аас 10, ОНАЗСХО-аас 1, ОНХС-аас 52 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг оруулсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2. Төрийн болон орон нутгийн худалдан авах ажиллагааны талаар** | | | | | | | |
| 8 | 2.1 | Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу төлөвлөн, зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих | Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний тоо | 120 | 61 | 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ байхгүй бөгөөд орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх нийт 7 төсөл арга хэмжээ батлагдснаас тайлант үеийн байдлаар тендер зарлаж гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулагдан ажил бүрэн дуусч, ашиглалтад хүлээн авсан 5, дахин зарласан 2 төсөл арга хэмжээ байна.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн хувьд: худалдан авах ажиллагаа зарлах 25 төсөл арга хэмжээнээс 24 төсөл арга хэмжээний тендер шалгарч гэрээ байгуулагдсан, 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж оролцогч оролцоогүй тул дахин зарлагдаж байна. | 90 |
| **Зорилт 3. “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын аж үйлдвэржилт болон хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд** | | | | | | | |
| 9 | 3.1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний өрнүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | Дэмжлэг үзүүлсэн үйлдвэрийн тоо | - | 1 | Цагаан алт үндэсний хөдөлгөөний хүрээнд тус аймагт улсын төсвийн санхүүжилт хуваарилагдаж ирээгүй боловч малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг дэмжих зорилгоор ЖДҮХСангаас арьс шир боловсруулах чиглэлээр Есөнбулаг сумд “Базгайн хөх эрчис” ХХК-д 100.0 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд тус аж ахуйн нэгж нь үйлдвэрийн байрыг барьж ашиглалтад оруулсан. Тус үйлдвэр нь жилд 5000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын болон БНХАУ-ын зах зээлд нийлүүлж байна. Мөн Турк улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ТИКА төслөөс “Артис алтай” хоршоонд 58.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Дэмжлэгийн үр дүнд тус хоршоо нь ноосон эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ 20 хувиар нэмэгдүүлсэн. | 100 |
| 10 | 3.2 | “Шинэ хоршоо” хөдөлгөөн “Чинээлэг малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах жиллана. | Хамрагдсан хоршооны тоо | 407 | 20 | “Шинэ хоршоо чинээлэг малчин” үндэсний хөдөлгөөний хүрээнд тайлант онд 143 хоршоонд 4,394,380 төгрөгийн зээл олгосон байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 3.3 | “Өрх бүрт өсөлт, иргэн бүрт орлого” арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болсон залуу малчин өрхийг малжуулах ажлыг зохион байгуулах | Малжуулахад хамрагдсан өрхийн тоо | 81 малчин өрх | 20-оос доошгүй | Мал хамгаалах эргэлтийн сангаас 5 өрхийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 34 өрхийг 256.0 сая төгрөг буюу 3695 (хонин толгойд шилжүүлснээр) толгой малаар малжуулсан байна. Залуу малчин 40 өрхийн холбогдох баримт материалыг нэгтгэн хүлээн авч, малжуулах ажлыг энэ онд багтаан хийхээр төлөвлөж байна. Сумдад 55 өрхийг 2512 толгой малаар малжуулсан байна. | 100 |
| 12 | 3.4 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх | Шинээр гаргаж ашиглалтад оруулсан инженерийн хийцтэй худгийн тоо | 28 худаг шинээр гаргасан | 5-аас доошгүй | Улсын төсвийн 45.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Уул, Бугат, Дарив, Тонхил, Хөхморьт, Шарга сумдад нийт 33 цэг байршилд газрын доорх уст цэгийн хайгуулыг “Ус-Амьдрал” ХХК хийж гүйцэтгэсэн. Орон нутгийн төсвийн 198.0 сая төгрөгийн санхүүжилтээр 18 сумд нийт 72 цэг байршилд уст цэгийн хайгуулын ажлыг “Гранд холдинг” ХХК-аар хийлгэж, ашиглалтад хүлээн авсан. Улсын төсвийн 67.9 сая төгрөгийн санхүүжилтээр Шарга, Есөнбулаг сумд инженерийн хийцтэй 2 худаг шинээр гаргах ажлыг "Гранд холдинг" ХХК-аар гүйцэтгүүллээ. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 303.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Уул, Тонхил, Эрдэнэ сумдад тус бүр 3, Чандмань, Есөнбулаг сумдад тус бүр 1, нийт 11 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргаж хүлээн авлаа. Хан-Алтай ресурс ХХК-ийн 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Наран багийн Үхэр чулуутад бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худгийг гаргаж малчдад хариуцуулан өглөө. | 100 |
| 13 | 3.5 | Бугат сумд өсгөн үржүүлж байгаа нутгийн хөвчийн улаан ямааг үүлдэр, омгоор батлуулах. | Бугатын хөвчийн улаан ямааг омог хэвшлээр батлуулах | Арга зүйг батлуулсан | Үүлдэр омгийг батлуулах | Бугат сумд үржүүлэгдэж байгаа “Хөвчийн улаан ямааны аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн үндсэн үзүүлэлтийг тогтоох” ажлыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж байна. Монгол Улсын Төрийн Соёрхолт зөвлөх малзүйч Б.Мандахтай хамтран ажиллах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан, Хөвчийн улаан ямааны тодорхойлолтыг хянан засварлах, сайжруулах, үржлийн ажлын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулаа. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Их эрдмийн зөвлөлийн хурал, ямааны аж ахуйн биологи ашиг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шимийн хурал, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлуудаар тус тус хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | |
| 14 | 3.6 | Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хувийн хэвшлийг дэмжиж ажиллах | | 2 хоршоо зээл хамрагдсан | 1-ээс доошгүй аж ахуйн нэгж, иргэнд дэмжлэг олгох | Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр Керей үүлдрийн хонины цөм сүрэг бүхий өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан Эдельбай үүлдрийн хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашиглаж байна. Дээрх цөм сүргийн хонийг 1 малчинд гэрээгээр эзэмшүүлээд байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баяд үүлдрийн 40 толгой хээлтүүлэгчийг худалдан авч сайжруулагчаар ашиглаж байна. Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сүүний үйлдвэрийг дэмжих хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгөөр Алатау үүлдрийн тугалтай 7 үнээ, мал хамгаалах сангийн 48.0 сая төгрөгийн зээлээр сүүний чиглэлийн 8 үнээ тус тус нийлүүллээ | 100 |
| **Зорилт 4. Газар тариалан жимс жимсгэнэ-108 сая мод тарьж ургуулах төсөл арга хэмжээний хүрээнд** | | | | | | | |
| 15 | 4.1 | Жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх | Тариалсан талбайн хэмжээ | 130 | 140 | Энэ онд 1954.3 га талбайд тариалалт хийж, 3615.75 тн ургац хураан авлаа. “Монголын унаган байгаль хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хамтарсан 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр 16 га талбайд Жимс жимсгэний аж ахуй байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.<br>Хаврын тарилтаар 130.3 га талбайд жимс, жимсгэний тариалалт хийж, 151 тн ургац хураан авлаа. Намрын тарилтаар Бигэр, Халиун сумдын мод үржүүлгийн газарт 4 нэр төрлийн 23200 ширхэг жимсний суулгацыг 10.3 га талбайд тариалж, нийт жимс жимсгэний тариалалтыг 140.6 га талбайд хүргэлээ. | 100 |
| 16 | 4.2 | Шинээр болон шинэчлэх, сэргээн засварлах усалтын системийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх | Услалтын системийн тоо | 2 | 1-ээс доошгүй | “Атрын IV” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд Дэлгэр сумын Гуулин тосгонд шинээр 50 га талбайд ногоон тэжээл тариалж, усалгаатай талбайн хэмжээг 1385 га-д хүргэлээ. | 100 |
| 17 | 4.3 | Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, газар олгох, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 240 мкв2 бүхий 2 хүлэмж | 120мкв 1-ээс доошгүй хүлэмж | Есөнбулаг сумын Естийн аманд орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр 300 мкв зуны хүлэмж 2 ширхэг, уртасгасан хугацаатай 300 мкв бүхий давхар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинээр байгуулсан | | хүлэмж 1 ширхэг, нийт 900 мкв 3 ширхэг хүлэмж барьж ашиглалтад оруулж, 4 төрлийн нарийн ногоо тариалж 1 тн ургац хураан авлаа. Есөнбулаг сумын төвд сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр тус бүр 300 мкв бүхий 4 ширхэг зуны хүлэмж барьж ашиглалтад оруулж, 5 төрлийн нарийн ногоо тариалж 1.5 тн ургац хураан авлаа. Тайлант онд нийт 2100 мкв хүлэмжийн талбайд шинээр тариалалт хийлээ. | |
| 18 | 4.4 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “108 сая мод тарьж, ургуулах” арга хэмжээг хэрэгжүүлэх | Тариалсан талбайн хэмжээ болон суулгацын тоогоор | 101198 ш мод | 143198 ш мод | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 30,0 сая төгрөгөөр "Нутгийн төгөл" ХХК 3000 ширхэг заг, 1000 ширхэг хармаг тарих, 2000 м услалтын систем угсрах ажлыг Цогт сумын Ээж уулын отоглох цэгийг түшиглэн хийж дуусгасан. Эрдэнэ сумд Ensure төслийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Баян Зармангийн бүрд" ТББ 2 га талбайг хашиж хамгаалан 5000 ширхэг заг тарилаа. Нийт 9000 ширхэг заг тарьж, амьдралтын хувь 85-аас дээш байна.<br>Хавар, намрын мод тарилтаар Есөнбулаг сумд 73700, бусад сумдад 131682, нийт 8 төрлийн 205382 ширхэг мод, бут тарих ажлыг зохион байгууллаа. Модны амьдралтын хувь 75-аас дээш байна. | 50 |
| **Зорилт 5. Эрүүл хүнс арга хэмжээг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангаж, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 19 | 5.1 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх | Хүнсний улиралын нөөцийг бүрдүүлэлт | - | 1 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд “Буудайн хөх уулс” ХХК-тай гэрээ байгуулан хүнсний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100 |
| 20 | 5.2 | Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх | Хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хувийг 2-оос доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | - | Хангамжийн хувийг 2-оос доошгүй хувиар нэмэгдүүлнэ | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхээр “Буудайн хөх уулс” ХХК-тай гэрээ байгуулсан. Гол нэрийн 10 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс дотоодын үйлдвэрлэлээр махыг 100 хувь, сүүн бүтээгдэхүүний 48 хувь, гурилын 9 хувь, гурилан бүтээгдэхүүний 59 хувь, төмсний 11.4 хувь, хүнсний ногооны 17.5 хувь, жимс, жимсгэний 14 хувийг хангаж байна. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг foodsupply.mofa.gov.mn программаар хянадаг бөгөөд 11 сарын байдлаар мах 40.2 тн, гурил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 171.6 тн, гурилан бүтээгдэхүүн 17.1 тн, төрөл бүрийн будаа 86.9 тн, ургамлын тос 11.3 тн, хуурай сүү 8.3 тн, өндөг 1.6 тн, төмс 59.3 тн, хүнсний ногоо 55.2 тн, элсэн чихэр 58.5 тн, давс 12.1 тн, цэвэр ус 35.1 тн-ийн нөөцтэй байна. | |
| 21 | 5.3 | Нийтийн хоолны чанар хүртээмжийг сайжруулж, орон нутгийн онцлог бүхий уламжлалт брэнд хоол, идээ ундааг шинээр бий болгох хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх | Арга хэмжээний тоо | - | 5-аас доошгүй | Хантайшир тогоочдын холбоотой Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран Дарив сумд хойд бүсийн тогоочдын үзэсгэлэн сургалтыг 4 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Тус сургалт үзэсгэлэнд Тонхил, Дарив, Шарга сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмнэлгийн тогооч нар хамрагдаж орон нутгийн онцлогтой сультай цай, борви тойгтой хоол, цай, арвай, сультай боорцог, ингэний хоормог, хөөрцөг зэрэг бүтээгдэхүүнээр хоолны нэр төрлөө баяжуулсан байна. Дэлхийн тогооч нарын өдрийг тохиолдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсролын газартай хамтран сургууль цэцэрлэгийн 90 тогоочид "Хүнсний бүтээгдэхүүний шим тэжээл", "Эрүүл ахуйн зохистой дадал", "Хүнсний аюулгүй байдлын чиглэл"-ээр сургалтыг зохион байгуулсан.<br>Аймгийн аварга тогооч шалгаруулах ажил мэргэжлийн уралдааныг 12 дугаар сарын 6,7-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд хоол үйлдвэрлэлийн чиглэлээр 67 иргэн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. | 100 |
| 22 | 5.4 | Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, хийж, зөвлөн туслах ажлыг зохин байгуулах | Хяналт шалгалтад хамрагдсан цэгийн тоо | Худалдааны **140,** хоол үйлдвэрлэлийн **41**, нийт 181 обьектийг урьдчилан сэргийл | | Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа "Хүнсний хувьсгал хөдөлгөөн", Засгийн газрын 36 тогтоолын хүрээнд 2023-2025 онд "Хүнсний аюулгүй байдал" аяныг зохион байгуулан төлөвлөгөөний дагуу 18 сумын 3400 гаруй иргэд, хүнсний үйлдвэр, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгч нарыг хамруулан давхардсан тоогоор 14 удаагийн сургалтыг үе шаттайгаар чиглэл бүрээр зохион байгуулж, 43 төрлийн 6000 гаруй гарын авлага, зөвлөмж тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, иргэд болон сургуулийн хүүхдүүдэд хэрэглээний баталгаат хугацаа дууссан болон хаяг шошгын зөрчилтэй хүнсний бүтээгдэхүүнээр үзүүлэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эх хяналт шалгалтад хамруулсан. | | гарган шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхээс сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл түгээн ажилласан.<br>"Хүнсний аюулгүй байдал"-ын хүрээнд төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг сумдын хүнсний худалдаа, хүнсний үйлдвэр, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр хийж, давхардсан тоогоор 180 иргэн, 252 аж ахуй нэгжийг хамруулан 944 зөрчил илрүүлэн 516 буюу 55 хувийг арилгуулан ажилласан. Мөн хүнсний аюулгүй байдлын талаар ойлголт, зөв дадлыг төлөвшүүлэх зорилгоор 10 төрлийн постер хийж цахим хаягаар түгээн ажилласан. | |
| **Зорилт 6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжин бизнес эрхлэгчдийг төсөл, хөтөлбөрт хамруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ** | | | | | | | |
| 23 | 6.1 | Жижиг дунд үйлдвэрлэл, ахуй үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх | Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоо | 20 | 10 | "Атрын IV" тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд 2 аж ахуй нэгжид зоорийн үйл ажиллагаа эрхлэх, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 500.0 сая төгрөгийн, 9 хоршоонд 326.0 сая төгрөгийн, ахуйн үйлчилгээний чиглэлээр 1 хоршоонд 140.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Дээрх ажлын үр дүнд 12 ажлын байр шинээр бий болсон байна. | 100 |
| 24 | 6.2 | Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр үзэсгэлэн, форум, телевизийн нэвтрүүлэг, уулзалт зохион байгуулах | Үзэсгэлэн, форум зохион байгуулагдсан байна. | 4 | 4 | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтын орлогыг дэмжих зорилгоор "Цагаан сар-2025" үзэсгэлэн худалдааг 2 дугаар сард зохион байгуулж 70 гаруй хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцож 80.0 сая төгрөгийн борлуулалт хийлээ. "Алтайн алтан намар", "Хантайшир экспо-2025" үзэсгэлэн худалдааг 9 дүгээр сард зохион байгуулж 18 сум, Завхан аймгийн нийт 150 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид оролцож 95.5 сая төгрөгийн борлуулалт хийлээ. Мөн УБ хотод зохион байгуулагдсан "Амар байна уу", "Нүүдэлчин", "Олон улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа", "Намрын ногоон өдрүүд-2025" үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 24 иргэн, аж ахуй нэгжийг оролцууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 6.3 | Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодыг чадавхижуулж, зөвлөн туслах үйл ажиллагаа үзүүлж, хоршооны загвар төслүүдийг бэлтгэж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэн, сургалт зохион байгуулах | Чадавхижсан загвар хоршооны тоо | 360 | 10 | "Төсөл боловсруулах", "Компаний засаглал", "Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих", "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах, бүрдүүлэх бичиг баримтын талаар зөвлөгөө мэдээлэл өгөх", "Зээлийн батлан даалтын сангийн танилцуулга", "Малын гаралтай ширхэгтийн стандартыг танилцуулах, хоршооны хөгжлийг дэмжих, чадавхжуулах", "Арьс ширэн түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх" чиглэлээр нийт 7 удаагийн чадавхжуулах сургалтад хоршооны гишүүд, салбарын мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөл 530 хүнийг хамрууллаа. | 100 |
| **Зорилт 7. Мал эмнэлгийн чиглэлээр** | | | | | | | |
| 26 | 7.1 | Мал амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах | Дархлаажуулалтад хамрагдсан малын тоо | Жилд 2.2 сая хамруулж, 547.0 сая төгрөг зарцуулсан | 2,0 саяас доошгүй | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 92140 мал, амьтныг галзуугийн, 141897 малыг боомын, 310738 малыг дотрын халдварт хордлого-энтеробактериозын, 88291 малыг цусан халдварын, 4499 малыг дуут хавдрын, 19950 малыг сохор доголын, 179800 малыг шөвөг ярын вакцинд хамрууллаа. Биокомбинат ТӨХКК-тай байгуулсан гэрээний дагуу 210.3 сая төгрөгий вакцины үнэ, мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 286.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүллээ. Аймгийн хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 837317 малыг, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1352000 мал, нийт-2189315 мал, амьтан хамрууллаа. | 100 |
| 27 | 7.2 | Халдварт болон гоц халдварт өвчний эрт илрүүлгийн үзлэг тандалт, шинжилгээг тогтмол хийж баталгаажууллаа | Хамрагдсан малчин өрх болон дээжийн тоо | 1994 малчин өрхийн 16.5 мянган малаас цуглуулсан дээж | нийт малчин өрхийн 30-аас доошгүй хувь, 16,0 мянган дээж | Сумдын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар мал эмнэлгийн нэгдсэн системийн эрт илрүүлэг, хариу арга хэмжээний модулыг ашиглан гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь ямааны цэцэг, үхрийн арьс товруутах өвчнийг эрт илрүүлэх, өвчний тархалтын хүрээг тогтоох зорилгоор 18 сумын, 4037 малчин өрхийн 418 адуу, 49 тэмээ, 2501 үхэр, 7995 хонь, 8872 ямаа нийт-19835 малд үзлэг хийж, эрсдэлийн үнэлгээ хийн баталгаажууллаа. Дарив сумын Ихэс баг, Бигэр сумын Их булаг, Буудай баг, Баян-Уул сумын Алтангадас баг, Халиун сумын Олонбулаг баг, Дэлгэр сумын Баян-Өндөр багуудад галзуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчний 9 тохиолдол, Жаргалан сумын Бүрэн багт боом өвчний 1 тохиолдол, Дарив сумын Хужирт баг, Бигэр сумын Мянгай багт дотрын халдварт хордлого өвчний 2 тохиолдол, Баян-Уул сумын Алтангадас баг, Бугат сумын Биж багт колибактериоз өвчний 2 тохиолдол бүртгэгдэж, нийт-26 мал өвчилж, хариу арга хэмжээ авч ажиллалаа. | |
| 28 | 7.3 | Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ариутгал халдваргүйтгэлийн тусгай зориулалтын ДУК машинаар хангах | Нийлүүлэгдсэн сумын тоо | Мал угаалгын ванн-1 сум ДУК машин-3 | 4 сум | Халиун сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "Цас хан хөхий" ХХК-тай гэрээ хийн 60.0 сая төгрөгөөр, Цогт сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "ОТТО-МИР" ХХК-тай гэрээ хийн 58.8 төгрөгөөр, Хөхморьт сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "Арби Элваторс" ХХК-тай гэрээ хийн 55.8 төгрөгөөр,Тайшир сум ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "АЗХҮҮ" ХХК-тай гэрээ хийн 78.0 сая төгрөгөөр тус тус мал угаалгын Дук машиныг хүлээн авсан | 100 |
| **Зорилт 8. Аймгийн төв болон сумдын цахилгаан эрчим хүчний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 29 | 8.1 | Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кВ болгон өргөтгөх ажлын гүйцэтгүүлэн байнгын ашиглалтад оруулна. | 110кВт | 35кВт | 110кВт | Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кВ болгон өргөтгөх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ" ХХК шалгаран гэрээ байгуулан 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдөр байнгын ашиглалтад оруулаа. | 100 |
| 30 | 8.2 | Алтай хотод баригдах 25 мВт-ын хүчин чадалтай дулааны станц, дулаан дамжуулах төвийн барих ажлыг үргэлжлүүлэх | 25мВт | - | 25мВт | 25 мВт хүчин чадалтай дулааны станц барих ажлыг БНСУ-ын Экспорт-Импорт банкны санхүүжилтээр "Бьюксан инженеринг" ХХК ажлын явц 30 хувьтай гүйцэтгэсэн, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй барилгын ажил эхлээгүй, 2 орны Засгийн газар хооронд хэлэлцээр хийгдэж байна. Дулааны станц, дулаан дамжуулах төвүүдийн цахилгаан хангамжийн ажлыг улсын төсвийн 841.5 сая төгрөгөөр "Би Эм Жи Эл" ХХК, ус хангамж, ариутгах татуурга, холбоо мэдээллийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн 2,254.3 сая төгрөгөөр "Моденс" ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 24.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулааны станцын 2 дугаар хэлхээ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэд бүтцийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Одкон холдинг” ХХК шалгарч, ЭХЯамтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. 2025 онд Хөгжил хороолол болон УДДТ 1-н ус, дулаан хангамжийн шугамын ажлыг 20 хувьтай гүйцэтгэж байна. | |
| 31 | 8.3 | Хөгжил хорооллын дулааны эх үүсвэрийн зураг төсөв боловсруулна | Хэрэгжилтийн хувиар | - | 100 | Хөгжил хороололд шинээр дулааны эх үүсвэр барихаар “Санни сэрвис” ХХК-аар хүчин чадлын тооцоолол хийлгэн хүлээн авлаа. | 100 |
| 32 | 8.4 | Алтай хотод баригдах 25 мВт-ын хүчин чадалтай дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний ажлыг эхлүүлнэ | Хэрэгжилтийн хувиар | - | 70 | Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээ, дэд бүтцийн ажлын гүйцэтгэгчээр “Одкон холдинг” ХХК шалгаран авто замын байгууламж доорх шугамын ажлуудыг гүйцэтгэж байна. | 100 |
| 33 | 8.5 | Есөнбулаг сумын Баянхайрхан, Баяншанд, Индэрт багийн цахилгаангүй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангана. | Хэрэгжилтийн хувиар | - | 100 | Орон нутгийн хөгжлийн сангийн 1,300.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянхайрхан, Баяншанд, Индэрт багуудын шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын гүйцэтгэгчээр “Жи Би Юу И си” ХХК шалгаран Баянхайрхан багийн ажлыг эхэлсэн. | 70 |
| **Зорилт 9. Эрдэс баялаг, аж үйлдвэрийн чиглэлээр** | | | | | | | |
| 34 | 9.1 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хүлээн авч шийдвэрлэх | хүлээн авч шийдвэрлэсэн өргөдлийн тоо | 11 | 6 | Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Аймгийн засаг даргын 2025 оны 145 дугаар захирамжаар олгож, хайгуулын ажлын төлөвлөгөөг нь батлан ажиллаж байна.<br>Мөн 2 аж ахуйн нэгжээс 3 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар ирсэн хүсэлтийг хүлээн авч, анхан шатны шүүлт хийлгэхээр цахим системд оруулж, илгээлээ. | 70 |
| 35 | 9.2 | Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг таслан зогсоох, хамтарсан хяналт шалгалт хийх | илрүүлсэн зөрчлийн тоо | - | 5 | Аймгийн хэмжээнд хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг зөрчил гарч болзошгүй газруудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Цагдаагийн байгууллагатай хамтран 23 удаа зохион байгуулж ажилласны үр дүнд 6 сумын 56 иргэн /3 мотоцикл, 15 машин, 1 трактор, 5 мэдрэгч/-ийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, хууль хяналтын байгууллагад шилжүүллээ. | 100 |
| 36 | 9.3 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын | байгуулж, байрш | 5 | 12 | 2025 оны 4 дүгээр сард “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлье” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гэрээ байгуулж, байгуулсан гэрээг эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулах | уулсан гэрээний тоо | | | Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд энэ арга хэмжээнд аймгийн ИТХ, Засаг дарга,түүний Тамгын газар, сумдын ИТХ-ын болон Засаг дарга, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн удирдлага, инженер техник ажилтан зэрэг 100 гаруй хүмүүс оролцлоо.<br>Холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч 18 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээг байгуулан ажиллаж байна. | |
| **Зорилт 10. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр** | | | | | | | |
| 37 | 10.1 | Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах 2025-2030 он хүртэлх 5 жилийн төлөвлөгөөг бүсийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах /жилийн төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллах/ | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь | - | 90-өөс доошгүй | Аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 10 зорилт бүхий 65 арга хэмжээг тусгасан 2030 он хүртэл хэрэгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах болсон тул холбогдох байгууллагуудаас дата мэдээллийг цуглуулан нөлөөллийн шинжилгээг хийлээ. "Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах 2025-2030 он хүртэлх 5 жилийн төлөвлөгөө"-г аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталлаа. | 90 |
| 38 | 10.2 | Зэрлэг амьтны усан хангамжийг сайжруулах зорилгоор шинээр хөв, услалтын систем байгуулах | Шинээр байгуулсан хөв цөөрөм, услалтын системийн тоо | 2 | 2 | Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран Дарив сумын Овоотын булгийн урсгалыг түшиглэн 3 байршилд жижиг цөөрөм, 1 байршилд хөв хийхээр төлөвлөж байна. | 50 |
| 39 | 10.3 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, дагалдах журмын хэрэгжилтийг хангаж, орон нутгийн суурь зардалд туссан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг ИТХ-аар батлуулан (газар, ой, амьтан, ургамал, ус рашаан) хэрэгжилтийг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх | Хуулийн хэрэгжилтийн хувь, мөнгөн дүн Батлагдсан ИТХ-ын тогтоолын хавсралт (СЯ-наас баталсан дүнг үндэслэх) | 85.3% ИТХ-ын тогтоол гаргуулах | 100 хувь | Энэ онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2,7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 604,0 сая төгрөгийг зарцуулан хуулийн хэрэгжилтийг 107 хувь хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар уг арга хэмжээнд тодотгол орж, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 809,0 сая төгрөг, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 239.4 сая төгрөгийг буцаан зарцуулахаар батлагдлаа. Тодотголоор | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлагдсан энэхүү санхүүжилтийн хүрээнд 8 ажил төлөвлөж, тэдгээрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа. Аймгийн 18 сум тус бүр ИТХ-ын тогтоол гарган Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс нийт 1,8 тэрбум төгрөг төвлөрүүлж, Хуулийн дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд 320,0 сая төгрөгийг буцаан зарцуулахаар тусгаж, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж тодорхой ажлуудыг зохион байгуулж байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, буцаан зарцуулалтын аймаг, сумдын нэгдсэн гүйцэтгэлийг журмын дагуу 2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тайлагнах үүрэгтэй бөгөөд, тайлагналын хугацаа болоогүй тул эцсийн гүйцэтгэл хүлээгдэж байна. | |
| 40 | 10.4 | Хөрсний бохирдлыг бууруулах замаар аж ахуйн нэгж, албан байгууллага, гэр хороололд стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | Стандартын шаардлагад нийцсэн жорлонгийн хувь | 10 | 15 | Аймгийн төвийн 68, хөдөөгийн сумдын 155, нийт 223 айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүд өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан эко жорлонтой болсон. | 70 |
| 41 | 10.5 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг хийж Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, бүсэд мөрдөх журмыг батлах | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Ус, цаг уур орчны шинжилгээний төвтэй хамтран нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд халаалтын зуухны 68, айл өрхийн 5903 агаар бохирдуулагчийн эх үүсвэр бүртгэгдсэн байна. Мөн Хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр 16653 авто тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. | 50 |
| 42 | 10.6 | Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га-аар | ХАМО-95.87 | 17 | 2025 онд аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын 6, геологийн эрэл хайгуулын 26, метан хийн хайгуулын 1, нийт 33 аж ахуй нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 17 удаагийн хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж холбогдох арга хэмжээг авч ажилласан. Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 аж ахуй нэгжээр нийт 4.2 га талбайд нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэн хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ашигт малтмал хууль бусаар олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд “Хан-Алтай Ресурс” ХХК, “Цэнгазар” ХХК, “Сэкер ресорсус монголиа” ХХК-ууд дүйцүүлэн хамгаалал болон нийгмийн хариуцлагын хүрээнд 26.15 га, орон нутгийн төсвөөр 2.5 га, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд 4.46 га, нийт 33.11 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэн хүлээн авсан. | |
| 43 | 10.7 | Сумдад хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах, гол, булаг шандны урсацын тохируулга хийх замаар хөв цөөрөм, усан сан байгуулах | Хөвийн тоо | 8 | 4 | Хан Алтай ресурс ХХК-ийн Говь-Алтай аймгийн Засаг дарга, Есөн булаг сумын Засаг дарга нартай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Говь-Алтайн аймгийн 3 сумын 4 байршилд хөв цөөрөм байгуулах ус зүйн тооцоолол хийж ус хуримтлагдах талбайг тооцоолж зураг, төсөв боловсруулах ажлыг “Гидродизайн инноваци” ХХК-тай 2025 оны 1 сард гэрээ байгуулан ажиллаж байна.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас санаачилсан Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд Говь-Алтай аймаг 2025 онд Улсын төсвөөр 15 хөв цөөрөм байгуулах ажлыг эхлүүлсэн. Шинээр хөв байгуулах байршлыг тогтоох ажлыг сав газрын захиргаад болон сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж байна. 3 байршилд батлагдсан зураг төсвийн дагуу хөв байгуулна. Хөхморьт сумын Хөлийн усны хөв байгуулах ажил эхэлсэн явагдаж байна. | 90 |
| 44 | 10.8 | Агнуур зохион байгуулалтын менежментийг сайжруулан байгалийн нөөцийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх | ОНТөсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ | 320,0 сая | 320,0 сая-аас доошгүй | Агнуур зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, судалгааг батлуулан ажилласнаар агнуурын 7 бүс нутгийг шинээр нэмж нийт 10 сумд 13 агнуурын бүстэй боллоо. Агнуурын бүс нутгуудад аймгийн хэмжээнд 2 толгой угалз, 20 толгой тэх агнуулж, орон нутгийн төсөвт 322,9 сая төгрөг төвлөрүүллээ. | 100 |
| **Зорилт 11. Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн байгууламжийн засвар арчлалтыг гүйцэтгэнэ** | | | | | | | |
| 45 | 11.1 | Ентүм зочид буудлаас 3,4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх авто зам, хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг Хөгжил | Ажлын гүйцэтгэлээр | 30% | 100 | Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрын хойд талын уулзвар хүртэлх авто зам, Хийдийн 60 авто машины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжны хатуу хучилттай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжинд хатуу хучилттай авто замын ажлыг ашиглалтад оруулна | | | | авто замын ажлын гүйцэтгэгчээр “Сакод импорт” ХХК шалгаран 600м авто замын хучилтыг хийж, явган зам, бродюрын ажил хийгдсэн. | |
| 46 | 11.2 | Аймгийн төвийн хатуу хучилттай 15,6км авто замын ажлыг эхлүүлнэ | Ажлын гүйцэтгэлээр | - | 30 | Аймгийн төвийн 15,6 км хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэгчээр “Бумбат даваа” ХХК шалгаран 10 км замын далангийн ажил хийгдсэн. | 100 |
| 47 | 11.3 | Есөнбулаг сумын авто зогсоолуудыг өргөтгөх засварлах | Ажлын гүйцэтгэлээр | - | 100 | Тус төсөл арга хэмжээний хүрээнд Батсуурийн гудамжны тохижилт, “Их” буудал дэлгүүрийн зүүн талын зогсоол, Жинст багт 3 дугаар цэцэрлэгийн урд автозамын зогсоолын зураг төсвүүдийг хийсэн. Мөн 2026 онд дээрх төсөл арга хэмжээг аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийдийн 60 автомашины зогсоолыг тус тус хийхээр төлөвлөсөн. | 100 |
| 48 | 11.4 | Цогт сумын төвд баригдах 1км цемент бетон хучилттай авто зам ашиглалтад оруулна. | Ажлын гүйцэтгэлээр | 0% | 100 | Тус төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2025 оны А/52 дугаар захирамжийн дагуу Цогт сумын Засаг даргад эрх шилжүүлсэн бөгөөд сумаас тендерийг 3 дахь удаагаа зарлаж, тендерт 1 оролцогч оролцсон боловч шаардлагад нийцээгүй тул тендер хүчингүй болж дахин зарландан он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | 90 |
| 49 | 11.5 | Шарга сумын Баянгол багийн гүүрийг шинээр барьж ашиглалтад оруулна. | Ажлын гүйцэтгэлээр | 0% | 100 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Шарга сумын Баянголын гүүрийг засварлах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зарласан. Улсын төсвийн 8,928.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалан сумын Бүрэн багийн гүүрийг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчээр “Эвт уул” ХХК шалгаран гүүрийн далан, суурийн ажил хийгдсэн. | 50 |
| **Зорилт 12. “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил” төсөл хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 50 | 12.1 | Эрдэнэ, Бугат, Шарга сумдад баригдаж буй 50 м3/хоног бүхий хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь (дундаж) | 58% | 100 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 552.0 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэ сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Шатат” ХХК, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 582.1 сая төгрөгийн хөрөнгөөр Бугат сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Жи гоулд” ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. ОНХС-ийн 552.4 сая төгрөгийн хөрөнгөөр Шарга сумын цэвэрлэх байгууламжийн ажил “Жи гоулд” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сард улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажил хангаж байна. | |
| 51 | 12.2 | Баян-Уул сумд баригдаж буй 50 м3/хоног бүхий хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. | Барилгын гүйцэтгэлийн хувь | 10 | 70 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 541.4 сая төгрөгийн хөрөнгөөр Баян-Уул сумд баригдаж буй 50 м3/хоног бүхий хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг “Жи гоулд” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 12 сард улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажил хангаж байна. | 100 |
| 52 | 12.3 | Солонго хорооллын инженерийн шугам сүлжээ бүхий газарт нийтийн болон амины орон сууцны барилга барих ажлыг үргэлжүүлнэ. | Айлын тоо | 330 | 288 | Есөнбулаг сумын Баянхайрхан баг, Солонго хороололд хувийн хөрөнгө оруулалтаар 397 айлын 8 барилга, шугам сүлжээний хамт баригдаж, ашиглалтад орсон. Мөн 548 айлын 10 орон сууцны барилга баригдаж байгаа бөгөөд тус барилгуудын гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. | 100 |
| 53 | 12.4 | Алтай, Бигэр сумдыг халаалтын нэгдсэн системд холбох ажлыг ашиглалтад оруулна. | Ашиглалтад оруулсан төслийн тоо | - | 2 | Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилгын ажлыг УТ-ийн 2493,8 сая төгрөгөөр “Сити агро эх” ХХК-аар гүйцэтгүүлж, 2025 онд ашиглалтад оруулсан. Алтай сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамжийн төслийг УТ-ийн 10,192.7 сая төгрөгөөр "Тунгалаг говь транс" ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 100 хувьтай. 12 сард улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажил хангаж байна. | 100 |
| 54 | 12.5 | Аймгийн төвийн цэвэр усны болон ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн шинэчлэх ажлыг эхлүүлнэ. | Шугам сүлжээний гүйцэтгэлийн хувь | - | 30 | Аймгийн төвийн цэвэр усны шугам сүлжээг хэсэгчилсэн солих ажлын трассыг аймгийн Засаг даргын 2025.06.24-ний өдрийн А/361 дугаар захимжаар баталж, “Сойл трейд” ХХК-аар инженер геологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлж, “Нью товер” ХХК зураг төслийг гүйцэтгэж, магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн.<br>Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн шинэчлэх ажлын зураг төсвийг “Алтан босгот өргөө” ХХК боловсруулж, хүлээлгэн өгсөн.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Аймгийн төвийн ариутгах татуургын шугам сүлжээг хэсэгчлэн солих” ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2,150,719,605 төгрөгийн дүнтэй ГААХААГ/20250101119 дугаартай гэрээг “Техвейр” ХХК-тай 2025.06.30-ны өдөр байгуулж, барилга угсралтын ажил 30 хувьтай байна. | |
| 55 | 12.6 | Харзат, Индэрт багийн гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холбох ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь (дундаж) | 55 | 100 | Улсын төсвийн 1,160.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Харзат багийн инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын ажлыг “Энержи плас инженеринг” ХХК гүйцэтгэж, дулаан хангамжийн шугам, ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж дууссан.<br>Улсын төсвийн 940.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Индэрт багийн инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын ажлыг “Вентана констракшн” ХХК-аар гүйцэтгэж, дулаан хангамжийн шугам, ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж дууссан. | 100 |
| 56 | 12.7 | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтцийн ажлын угсралтын ажлыг эхлүүлнэ. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 10 | Улсын төсвийн 24.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтцийн ажлын угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Одкон холдин” ХХК шалгарч, ЭХЯамтай гэрээ байгуулсан. Ажлын явц 20 хувьтай. | 100 |
| 57 | 12.8 | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, ус, ариутгах татуургын шугам сүлжээний угсралтын ажлыг эхлүүлнэ. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | 10 | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтцийн багц 2 буюу ус, ариутгах татуурга, мэдээлэл холбооны шугам сүлжээний угсралтын ажлыг улсын төсвийн 2,254.3 сая төгрөгөөр “Моденс” ХХК гүйцэтгэж, ЭХЯамнаас улсын комисс ажилласан. | 100 |
| 58 | 12.9 | Бигэр сумын сургууль, цэцэрлэг, спорт заалны барилгын дулаан хангамжид холбоно. | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Бигэр сумын сургууль, цэцэрлэг, спорт заалны барилгын дулаан хангамжид холбох ажлын зураг төслийг “ДНТ” ХХК боловсруулж хүлээлгэн өгсөн.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 209.0 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжигдэх “Бигэр сумын сургууль, цэцэрлэг, спорт заалны барилгын дулаан хангамжид холбох” ажлын гүйцэтгэгчээр “Тэнүүн алтай шарга” ХХК шалгарч, 2025.11.03-ны өдрийн ГААХААГ/20250101138 дугаар гэрээ байгуулсан. Ажлын явц 100 хувьтай. Улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажил хангаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 13. Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга, бүтээн байгуулалтын ажлын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс талуудын харилцан уялдааг хангаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллана.** | | | | | | | |
| 59 | 13.1 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг, Цогт, Тайшир, Баян-Уул, Тонхил, Бигэр сум, Баянтоорой тосгонд баригдаж буй 8 барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна. | ашиглалтад орсон барилгын тоо | - | 8 барилга | Улс, орон төсвийн хөрөнгөөр баригдсан Баян-Уул, Тайшир сумын Засаг даргын тамгын газрын барилга, Цээл, Тонхил, Цогт сумын спорт заалны барилга, Цээл сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Есөнбулаг сумын 320 хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн барилгыг тус тус ашиглалтад оруулж, Баян-Уул сумын 160 ортой, дотуур байрны барилга, Баянтоорой, Дарив, Бигэр сумын спорт заалны барилгыг ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажил хангаж ажиллаж байна. | 100 |
| 60 | 13.2 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дэлгэр, Дарив, Халиун, Есөнбулаг сумд шинээр баригдаж буй 5 барилга угсралтын ажлыг үргэлжүүлнэ. | Барилгын гүйцэтгэлийн хувь (дундаж) | 5 | 50 | Дэлгэр сумын 100 ортой дотуур байрны барилгын ажлыг улсын төсвийн 2,744.5 сая төгрөгөөр "Их морьт эрдэнэ" ХХК-аар гүйцэтгүүлж, ажлын явц 60 хувь, Халиун сумын спорт заалны барилгыг улсын төсвийн 1,567.4 сая төгрөгөөр "Ар-Онгот" ХХК гүйцэтгүүлж байгаа ажлын явц 90 хувь, улсын төсвийн11,647.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 640 суудалтай өргөтгөлийн барилгын ажлыг "Грэйт майнинг" ХХК гүйцэтгэж, ажлын явц 30 хувь, Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилгын ажлыг "Зэвсэгт хүчний 340 дүгээр цэргийн анги" ажлын явц 85 хувьтай тус тус гүйцэтгэж байна. Дарив сумын спорт заалны барилгыг ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажил хангаж байна. | 100 |
| 61 | 13.3 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг, Халиун сумд шинээр эхлэх барилга, их засвар, гудамжны тохижилт, шинэчлэлтийн ажлыг эхлүүлнэ. | Эхэлсэн төсөл арга хэмжээний тоо | - | 3 | Улсын төсвийн 11,647.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын "Хантайшир-Эрдэм" цогцолбор сургуулийн 640 суудалтай өргөтгөлийн барилгын ажлыг "Грэйт майнинг" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 3,028.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, барилгын талбайд гадна цахилгааны шугам сүлжээний, газар шорооны, суурийн болон 1-р давхрын төмөр бетон карказын ажил, А, В, Д блокын 2 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | давхрын төмөр бетон карказын ажлууд хийгдсэн байна. Ажлын явц 30.0 хувьтай.<br>Халиун сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг улсын төсвийн 1969.0 сая төгрөгөөр "Модон чөлөө" ХХК гүйцэтгэж, Ажлын явц 90.0 хувьтай. 2025 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.<br>Есөнбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 1,228.0 сая төгрөгийн хөрөнгөөр Батсуурийн гудамжны тохижилтын ажлын "Гранд мөнх буурал" ХХК гүйцэтгэж, ажлын явц 95 хувьтай байна.<br>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 611.2 сая төгрөгийн хөрөнгөөр "Говь-Алтай аймгийн төв Алтай хотын Лодойдамбын гудамжны тохижилт, шинэчлэлт"-ийн ажлын гүйцэтгэгчээр "Гуулин зам" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. | |
| 62 | 13.4 | Солонго хорооллын инженерийн шугам сүлжээ бүхий газарт нийтийн болон амины орон сууцны барилга барих ажлыг үргэлжүүлнэ. | Орон сууцны айлын тоо | 330 | 288 | Есөнбулаг сумын Баянхайрхан баг, Солонго хороололд хувийн хөрөнгө оруулалтаар 397 айлын 8 барилга, шугам сүлжээний хамт баригдаж, ашиглалтад орсон. Мөн 548 айлын 10 орон сууцны барилга баригдаж байгаа бөгөөд тус барилгуудын гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. | 100 |
| 63 | 13.5 | Алтай хотын Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна. | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 115.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААХААГ/20250103037 дугаартай Алтай хотын Солонго хороолол орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр "Циркулпроект" ХХК шалгарч, гэрээний байгуулж, ажлын явц 70 хувьтай. | 70 |
| 64 | 13.6 | Алтай хотын Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулна. | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Алтай хотын Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа тус ажил хэрэгжинэ. Хугацаа болоогүй. | - |
| 65 | 13.7 | Дарив сумын нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг дуусгана. | Хэрэгжилтийн хувь | 10 | 100 | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 33.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дарив сумын нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугамын зураг төсөл боловсруулах ажлыг "Мөнх консалтинг" ХХК гүйцэтгэхээр тендерт шалгарч, гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй учир | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр 24-ний өдрийн 1/1586 дугаар албан бичгээр гэрээг цуцалж, дахин гүйцэтгэгч сонон шалгаруулах худалдан авах ажиллагааг ГААХААГ/20250203142 дугаараар 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зарласан ба тендерийг 2025 оны 12 -р сарын 08 -ны өдрийн 10 цагт нээнэ. | |
| 66 | 13.8 | Баянхайрхан, Баяншанд, Индерт багуудад жишиг багийн зураг төслийг боловсруулна. | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Тус ажлын төсөв татагдсан учир хэрэгжүүлэх боломжгүй болсон. | - |
| 67 | 13.9 | Хөхморьт сумын наадмын талбай байгуулна. | Хэрэгжилтийн хувь | 95 | 100 | Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 259.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөхморьт сумын наадмын талбай байгуулах ажлыг "Виматек" ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 100 хувьтай. Аймгийн Засаг даргын 2025 оны А/430 дугаар захирамжаар ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах эрхийг Хөхморьт сумын Засаг даргад шилжүүлсэн. | 100 |
| 68 | 13.10 | “Эрдэнэ-Үйлдвэр” ТӨҮГ-ын нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэвийн байгууламжаар солих 1, 3, 4 багц ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна. | хэрэгжүүлсэн сум, төслийн тоо | 3 сум, 6 төсөл | 17 сум, 19 төсөл | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 5,518.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл” 4 ээлжээр хэрэгжин сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж, Дарив, Дэлгэр, Халиун, Эрдэнэ сум, Гуулин тосгоны сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламж, МСҮТ-ийн дотуур байр болон Есөнбулаг 8-р цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг бүрэн ашиглалтад оруулсан. Бусад сумдын ажил 50 хувьтай үргэжилж байна | 70 |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ | | | | | | | |
| 69 | 2.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, ХШҮХ-т хугацаанд нь хүргүүлэх | Тайлагналтын тоо | 12 | 2 | Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 2025 оны 1,2,3,4 дүгээрр сар, хагас жилийн хэлтэстэй холбоотой хэрэгжилтийг нэгтгэн ХШҮХ-т хугацаанд нь хүргүүллээ. | 100 |
| 70 | 2.2 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг | Тайлагналтын тоо | 2 | 2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | | | | газраас картлагдаж ирээгүй тул хагас жилийн байдлаар биелэлт гаргаагүй. | |
| 71 | 2.3 | Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллах | Тайлагналтын тоо | 2 | 2 | Тус бодлогын баримт бичгийг хууль, журамд заасан хугацаа буюу 2025 оны 07 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тус тус хүргүүлэн, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг хангаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, 47 дугаар тогтоолоор 91.5 хувьтай буюу "Үр дүнтэй" хэрэгжсэн гэсэн үнэлэлт, дүгнэлтийг авч ажиллалаа. | 100 |
| 72 | 2.4 | Аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг хууль, журамд заасан шалгууруудыг хангаж боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг авч, хуульд заасан хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах | Батлуулах бодлогын баримт бичгийн тоо | 1 | 1 | Аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны 41 дүгээр тогтоолоор хуульд заасан хугацаанд боловсруулан, батлуулсан бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2025 оны 01/2886 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг тусгах, улс, орон нутгийн 2026 оны төсөв батлагдсантай холбоотойгоор төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 9 дүгээр хуралдааны 49 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулллаа. | 100 |
| 73 | 2.5 | Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангаж, Эдийн засаг, хөгжлийн яам болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах | Тайлагналтын тоо | - | 1 | Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2024 оны биелэлтийг нэгтгэн ХШҮХ-т хүргүүлэн, 90.85 хувиар үнэлүүлж, тайланг ЭЗХЯ-нд аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/178 тоот албан бичгээр журамд заасан хугацаанд хүргүүллээ. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг өссөн дүнгээр нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, 45 дугаар тогтоолоор 92,2 хувьтай үнэлж, "Үр дүн гарсан" гэж дүгнүүллээ. | 100 |
| 74 | 2.6 | Аймгийг хөгжүүлэх 5 жилийн Үндсэн чиглэлийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан боловсруулж, хуульд заасан | Батлуулах бодлогын баримт бичгийн тоо | 1 | 1 | Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх | | | | үндэсний 10, салбарын 28 үр дүнгийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 55, хөтөлбөрийн 109 үр дүнг тодорхойлон батлууллаа. | |
| 75 | 2.7 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | хэрэгжилтийн хувь | 87.5 | 89 | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 02 сарын 11-ний өдөр боловсруулан, хэлтсийн дарга, удирдлагуудаар хянуулан, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/324 дугаар захирамжаар батлууллаа. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны биелэлтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, 46 дугаар тогтоолоор 93,9 хувийн гүйцэтгэлтэй үнэлж, "Үр дүнтэй" гэж дүгнэлээ. | 100 |
| 76 | 2.8 | Аймгийн ИТХ-ын 2025 оны тогтоолын хэрэгжилтийг хангах | Тайлагналтын тоо | 4 | 4 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын 2024 оны жилийн эцэс, 2025 оны 01, 02, 03 дугаар улирлын хэлтэстэй холбоотой биелэлтийг хугацаанд нь ТЗУХ-т хүргүүллээ. | 100 |
| 77 | 2.9 | Аймгийн Засаг даргын 2025 оны захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг хангах | Тайлагналтын тоо | Тухай бүрт тайлагнаж ажилласан | 4 | Хэлтэс, харьяа байгууллагуудай холбоотой захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| **ГУРАВ. Монгол Улсын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр** | | | | | | | |
| 78 | 3.1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 2024 оны гэрээний биелэлт 95,3 хувьтай | 95-аас доошгүй хувиар хэрэгжүүлэх | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хагас жилийн хэрэгжилтийн тайланг 2025.06.23-ны өдрийн 1/913 дугаар албан бичгээр гарган хүргүүллээ. Жилийн эцсийн биелэлт 96,0 хувьтай хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хянагдаж байна. | 100 |
| 79 | 3.2 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймгийн Засаг | Хэрэгжилтийн хувь | 96.1 | 96 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдтай аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | даргатай байгуулсан гэрээний 2025 оны хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | оны гэрээний хагас жилийн хэрэгжилтийн тайланг гаргаж, 2025.06.10-ны өдрийн 02/834 дугаар албан бичгээр хүргүүллээ. Жилийн эцсийн биелэлт 94,03 хувьтай хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хянагдаж байна. | |
| 80 | 3.3 | Эрчим хүчний сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2025 оны хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 97.0% | 94,7 | Эрчим хүчний сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хэрэгжилтийг нэгтгэж байна. 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор жилийн эцсийн биелэлтийг хүргүүлнэ. | - |
| 81 | 3.4 | Зам, тээврийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2025 оны хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 95.0% | 95,5 | Зам, тээврийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хэрэгжилтийг гаргаж 91,5 хувьтай Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хянагдаж байна. | - |
| 82 | 3.5 | Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 93.7 | 95,0 | Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг гэрээнд заасан хугацаанд гарган, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хянуулж, хагас жилийн байдлаар 80 хувьтай хангаж аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/854 албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв. Жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 94.6 хувьтай хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүллээ. | 90 |
| 83 | 3.6 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 2025 оны хэрэгжилтийг хангаж ажиллах | Тайлагналтын тоо | 2 | 2 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээний хагас жилийн биелэлтийг 2025.06.24-ний өдрийн 01/927 дугаар, жилийн эцсийн биелэлтийг 2025.12.04-ний өдрийн 01/1643 дугаар албан бичгүүдээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. | 100 |
| **ДӨРӨВ.ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ | | | | | | | |
| 84 | 4.1 | Байгууллага дээр зохион байгуулагдах сарын ажлыг хуваарийн дагуу зохион байгуулах | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 1 | Байгууллагын 2 дугаар сарын ажлыг хариуцан зохион байгуулж, тайланг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр албан хаагчдын хуралд тайлагнан ажиллалаа. 2025 оны 12 дугаар сард зохион байгуулах ажлыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 85 | 4.2 | Хэлтсийн 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэж өгөх | Хадгаламжийн нэгжийн тоо | 25 ш түр хадгалах нэгж | салбар бүрээр | 2024 оны 50 ширхэг хадгаламжийн нэгжийг архивт хүлээлгэн өгсөн байна. | 100 |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| **Д/д** | **Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ** | **Хүрэх түвшин** | **Хэрэгжүүлэх ажил** | **Эхлэх, дуусах огноо** |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 1. | Орон нутгийн болон бүсийн сургалтад оролцоно. | 3 | Засгийн газар болон Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс 2025 оны 01 дүгээр сарын 05, 06-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил хамтын шийдэл" уулзалтад тус аймгаас нийт 4 албан хаагч, мөн 02 дугаар сарын 13, 03 дугаар сарын 21-ний өдрийн цахим уулзалтад давхардсан тоогоор нийт 12 албан хаагч оролцсон байна.<br>Эдийн засаг, хөгжлийн яам, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй хамтран Улаанбаатар хотноо 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Монгол Улс болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал"-ыг танилцуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хэлэлцүүлэг, 2025 оны 11 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан "Монгол Улс болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах нь" сургалт, хэлэлцүүлэгт холбогдох албан хаагч оролцлоо. | 100 |
| 2. | Хариуцсан салбарын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажлын байрандаа суралцана. | 3 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025.01.31-ний өдөр батлагдсан удирдамжийн дагуу хариуцсан салбар байгууллага буюу харьяа агентлагт ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллан, зөвлөн, тусалж, арга зүйгээр ханган ажиллалаа.<br>Аймгийн Засаг даргын 2025 оны А/408 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу сумдын өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдал, архив албан хэрэг хөтлөлтийн урьдчилсан үзлэг хийж, байгууллагын үйл ажиллагаатай танилцан, холбогдох үүрэг чиглэлийг газар дээр нь өгч ажиллалаа. | 100 |

*Танилцсан:*
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

***Төсвийн Шууд захирагч***
Ш.ЭРДЭНЭБАТ
2025.12.10

*Хянасан:*
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО,

***Нэгжийн дарга***

ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ЧИНЗОРИГ

*Нэгтгэсэн:*
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН ***Мэргэжилтэн***

Р.ЦЭНД-АЮУШ